

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№20/524

ШУС, НУС

2019

МОНГОЛЫН ХҮЙН РАДИОГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЭРХ ЗҮЙН АСУУДАЛД

Г.Мэндхүү*, Д.Даваадулам**

* МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, доктор (Ph.D)

**МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн магистрант

Түлхүүр үг: хүйн радио, иргэний сэтгүүл зүй, олон нийтийн оролцоо, эрх зүйн зохицуулалт

Радиоог өмчийн хэлбэрээр нь төрийн, олон нийтийн, арилжааны гэж гурав хуваадаг гэсэн ойлголт түгээмэл байдаг. Коммунист тогтолцоотой Вьетнам, Куба, БНАСАУ, БНХАУ гэх мэт орнуудад хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь төрийн мэдэлд байдаг бол зарим пост-социалист орнуудад хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь төрийн, олон нийтийн, арилжааны гэсэн өмчийн олон хэлбэртэй байна. Үүний сонгодог жишээ нь ОХУ юм. Орос улс социалист тогтолцооноос татгалзаад 30 гаруй жил болсон хэдий ч өнөөг хүртэл төр нь өөрийн гэсэн радио, телевизтэй. Үүний зэрэгцээ арилжааны радио, телевизийн эрх зүйн байдлыг ч хуулиар зохицуулсан байдаг. Ихэнх ардчилсан орнуудад төр өөрийн мэдэлдээ хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхаас татгалзаж, үүний оронд олон нийтийн радио телевиз байгуулах, арилжааны радио телевизийг үүсгэн байгуулахыг бүрэн зөвшөөрдөг. Тэгвэл хэвлэл мэдээллийн хэрэгслийн өөр нэг өвөрмөц хэлбэр бол “community media” юм.

Радиоогийн өмчийн дөрөв дэх хэлбэр XX зууны хоёрдугаар хагасаас Өмнөд Америк болон Баруун Европын орнуудад бүрэлдэж эхэлсэн юм. XX зууны 40-өөд оны үед Өмнөд Америк тивийн орнуудад хүйн радио бий болжээ. Ядуурал, нийгмийн баялгийн тэгш бус хуваарилалт зэрэг нь хүйн радио байгуулагдах гол шалтгаан юм. Тухайлбал, Боливи Улсад “Radio de los Mineros” (Уурхайчдын радио) 1947 онд, Колумб улсад “Radio Sutatenza” (Колумб улсын жижиг хотын нэрээр нэрлэгдсэн) радио станц тус тус нээгджээ. Боливи Улсын “Radio de los Mineros” радио станцын мэдээллийн бодлого нь уурхайчдын хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулахад чиглэгдэж байлаа. Хамгийн гол нь уурхайчид өөрсдийн эрх ашгаа хамгаалж сурахад, хөдөлмөрөө шударга үнэлүү-лэх тухай асуудлыг зоригтой дэвшүүлж чаддаг болоход нь туслахыг гол зорилгоо болгожээ. Тэгвэл Колумб Улсын “Radio Sutatenza” нь хотынхоо оршин суугчдын боловсролын түвшинг дээшлүүлэхэд туслах зорилготой байв. Радиоог хотын шашны зүтгэлтний санаачилгаар үүсгэн байгуулсан аж.

Аливаа бүс нутгийн оршин суугчид, эсвэл нийгмийн тодорхой бүлэг

давхаргын мэдээллийн эрэлт хэрэгцээг хангахад чиглэгдсэн зорилтот нэвтрүүлэг явуулдаг радио станцыг хүйн радио (англ. community radio) гэж нэрлэдэг¹.

НҮБ-ын харьяа Соёл Шинжлэх Ухааны төрөлжсөн байгууллага ЮНЕСКО нь радиогийн энэ хэв маягийг анхнаас нь дэмжиж иржээ. Үндэстний цөөнх, ямар нэгэн шашны итгэл үнэмшлээрээ эвлэлдэн нэгдсэн бүлэг хүмүүс, эсвэл нийгэмд эзэлж байгаа ижил байр суурь (малчдын, жолооч нарын, буддын шашны улааны урсгал) зэрэг нь хүйн радиог байгуулах гол нөхцөл болдог. Хүйн радио нь олон ургалч үзлийг дэмжих, хүн өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулдаг гэж ЮНЕСКО-гийн мэргэжилтнүүд цохон тэмдэглэдэг. Нийгмийн хамгийн далд эмзэг бүлгийн эрх ашгийг хамгаалахад хүйн радио онцгой ач холбогдолтой юм. Нийгмийн ямар нэгэн бүлэг давхарга үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрхээ эдлэх, мэдээлэл солилцооны харилцаанд хамрагдах хэрэгцээгээ хангахад нь хүйн радио чухал талбар болдог юм. Хүлээн авагч (сонсогч) нар нь хүйн радиогийн эзэмшил, санхүүжилт, нэвтрүүлэг зохион байгуулах, нэвтрүүлгийн сэдэв агуулгыг тодорхойлоход оролцож болдог. Хүйн радиогийн нэвтрүүлгийг туурвиж байгаа уран бүтээлчид (нэвтрүүлэгч, хөтлөгч, найруулагч, эвлүүлэгч, продюсер,

техникийн ажилтнууд) гол төлөв сайн дурын ажилтнууд бөгөөд ихэнх тохиолдолд ажлын хөлс, урамшуулал авдаггүй. Өөрөөр хэлбэл, хүйн радио гэдэг нь ямар нэгэн бүс нутагт байгаа олон түмний санаачилга, идэвх оролцоотойгоор үйл ажиллагаа явуулдаг өвөрмөц байгууллага юм. Гэхдээ дэлхийн практикаас харахад хүйн радио станц нь 7-25 гишүүнтэй удирдах зөвлөлтэй байдаг. Хүйн радио нь нийгмийн асуудлыг мэдээлээд өнгөрөх төдийгүй нийгэм-соёлын амьдралын төв нь болж медиа-контентыг бүтээхэд өргөн олон түмнийг татан оролцуулж чаддаг. Хүйн радио нь хэн нэгэн хүний хувийн өмч биш бөгөөд санхүүгийн ашиг олох гэж чармайдаггүй. Олон нийтийн иргэний, соёлын, оюун санааны эрх ашгийг хамгаа-

лахыг эрхэмлэдэг нийгмийн бүлэг давхарга хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байх эрхтэй юм. Гэхдээ хүйн радиог байгуулахдаа төрийн эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байх ёстой. Арилжааны бус боловсролын байгууллага, эмэгтэйчүүдийн нийгэмлэг холбоо, спортын байгууллага, хөдөө аж ахуй эрхлэгчдийн эвлэл, нутгийн уугуул иргэд, мэргэжлийн холбоо, үйлдвэрчний эвлэл гэх мэт байгууллагууд хүйн радио станц байгуулж үйл ажиллагаа явуулах боломжтой юм.

Хүйн радио станцын үйл ажиллагаа нь нийгмийн бүлэг давхар-



Үндэстний цөөнх, ямар нэгэн шашны итгэл үнэмшлээрээ эвлэлдэн нэгдсэн бүлэг хүмүүс, эсвэл нийгэмд эзэлж байгаа ижил байр суурь (малчдын, жолооч нарын, буддын шашны улааны урсгал) зэрэг нь хүйн радиог байгуулах гол нөхцөл болдог. Хүйн радио нь олон ургалч үзлийг дэмжих, хүн өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулдаг



гын өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэгддэг. Хүйн радио станц нь:

- шударга нийгмийг байгуулахад хэрэгцээтэй нийгмийн өөрчлөлтийг дэмжих
- нийгмийн янз бүрийн бүлэг давхаргын эрхийг хамгаалах чиглэлийн төслийг хэрэгжүүлэхэд дэм болох
- нийгмийн бүлэг давхаргуудын дуу хоолойг нийгэмд ил тод хүргэх
- хүлээн авагчдын нийгмийн эрэлт хэрэгцээг анхаарлын төвд оруулах
- нийгмийн бүлэг давхаргын соёлын олон янз байдлыг хадгалах
- иргэдийг мэдээллийн үйл ажиллагаанд татан оруулах
- ашгийг өөрийн үйл ажиллагааны гол зорилго болгодоггүй

Хүйн радио станцын нэвтрүүлэг дамжуулагч төхөөрөмжийн хүчин чадал нь 100Вт хүртэл байдаг тул долгионоо түгээдэг газар нутгийн хүрээ нь 5 километрээс хэтэрдэггүй. Хүйн радио станцын сонсогчид нь нэг эсвэл зэргэлдээ оршдог хэд хэдэн жижиг тосгон, суурингийн оршин суугчид байдаг. Хүйн радио станцад зөөврийн компьютер, ердийн туузан магнитофоноос эхлээд CD тоглуулагч, микрофон, дууны удирдлагын төхөөрөмж, хальс тоглуулагч зэргийг ашигладаг. Хүйн радио станцын тоног төхөөрөмжийн хүчин чадал, ажиллах хүний нөөцөөс хамаараад өдөрт хэчнээн цагийн нэвтрүүлэг явуулах нь тодорхойлогддог. Арилжааны эсвэл олон нийтийн статустай радио станцтай харьцуулахад хүйн радио станц нь бага цагаар ажилладаг. Олон улсын жишгээр харахад хүйн радиогийн санхүүжилт нь хэд хэдэн эх үүсвэртэй байдаг. Үүнд:

- зар сурталчилгаа нэвтрүүлэх

- хөрөнгийн эх үүсвэр бий болгох зорилгоор дуудлага худалдаа, хонжворт сугалаа, захиалгаар дуу хөгжим нэвтрүүлэх
- төрийн болон төрийн бус байгууллагаас хандив авах, нэвтрүүлэг нь ивээн тэтгэгчтэй байх
- гишүүнчлэлийн хураамж

Хүйн ХМХ нь санхүүгийн тайлан гаргаж, сонсогчдод орлого зарлагынхаа тухай мэдээллийг тогтмол танилцуулж байх үүрэгтэй.

Хүйн радиогийн үйл ажиллагаанд тулгардаг гол асуудал бол хууль, эрх зүйн зохицуулалт юм. Хүйн радио үйл ажиллагаа явуулахын тулд төрийн эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авах хэрэгтэй. Гэтэл дэлхийн улс орнуудад хүйн радиогийн үйл ажиллагааг зохицуулах тусгайлсан хууль, журам байдаггүй. Улс бүр хүйн радиогийн эрх зүйн байдлыг янз бүрийн арга замаар зохицуулснаар өнөөг хүрчээ. Жишээ нь Энэтхэг, Гана, Испани, Ливан Польш улсад хүйн радиог арилжааны радиотой адилтган эрх зүйн байдлыг нь зохицуулжээ. Гэтэл Аргентин, Уругвай гэх мэт улсад хүйн радио станц үйл ажиллагаа явуулахдаа төрөөс ямар нэгэн зөвшөөрөл авдаггүй байна.

Хүн ам ихтэй улс орнуудад ашиглагдахгүй байгаа сул радио долгион дээр нэвтрүүлэг дамжуулах эрх авахын тулд тусгай сонгон шалгаруулалтад орж өрсөлддөг. Зарим улсад радио долгионыг ашиглах эрх авахын тулд дуудлага худалдаанд ч оролцох шаардлага гардаг. Жишээ нь Эль Сальвадор Улсад радио долгионыг ашиглах эрх олгохдоо дуудлага худалдаа зохион байгуулдаг. Харин Аргентин улсад долгионы эрх авах хүсэлт гаргасан байгууллагуудын дунд сугалаа зохион байгуулдаг. Радио нэвтрүүлэг

дамжуулах эрхийг ардчилсан байдлаар олгож байгаа сайн жишээ болж чадахгүй гэдэг нь илэрхий. Сугалаа зохион байгуулах, дуудлага худалдаагаар радио долгионыг худалдаж байгааг ЮНЕСКО сайшаадаггүй бөгөөд радио долгионы үелзэл бол нийт хүн төрөлхтний дундын баялаг гэсэн байр суурийг баримталдаг.

Хүйн өргөн нэвтрүүлгийн дэлхийн ассоциац (World Association of Community Radio Broadcasters) нь хүйн радио станцын үйл ажиллагааг зохицуулах, зөвшөөрөл олгох, долгион хуваарилах асуудлыг шийддэг төрийн хараат бус байгууллага улс орон бүрт байгуулагдах хэрэгтэй гэсэн зөвлөмжийг гаргасан байдаг.

Монгол Улсад 2011 онд “Глоб Интернэшнл” ТББ-ын дэмжлэгтэйгээр манай улсын Баян-Өлгий аймгийн Баяннуур, Улаанхус, Буянт суманд, Хөвсгөл аймгийн Цагааннуур, Улаан уул Цагаан уул суманд, Увс аймгийн Тэс, Зүүнговь суманд, Ховд аймгийн Алтай суманд хүйн радио станц нээжээ. Монголын хөдөө орон нутагт байгуулагдсан хүйн радиогоор дуу хөгжим, зар мэндчилгээ давамгайлдаг. 2019 оны нэгдүгээр улиралд “Глоб Интернэшнл”-ээс Хүйн хэвлэл мэдээллийн тогтвортой байдлын суурь судалгаа хийжээ. Судалгаанд хүйн радиотой 4 аймгийн 10 сумын оршин суугчдыг хамруулсан юм. Орон нутгийн засаг захиргаанаас гаргасан тогтоол шийдвэр, иргэдийн төлөөлөгч-дийн хурлын шийдвэр, банк, нийгмийн даатгал, тэтгэмж, татвар, даатгалтай холбоотой мэдээ мэдээлэл авахыг судалгаанд хамрагдсан сонсогчид хүсдэг байна. Үүнээс гадна хүйн радиогоор эмэгтэйчүүдийн эрхийн асуудал, гэр бүлийн харилцаанд тулгардаг бэрхшээл, архи тамхины хор

холбогдлыг таниулах, эрүүл мэндээ хамгаалах тухай зөвлөгөө мэдээлэл, гадаад хэлний хичээл, танин мэдэхүйн нэвтрүүлэг дамжуулбал илүү үр өгөөжтэй байх болно гэж орон нутгийн оршин суугчид хариулжээ².

2012 онд Монголын хүйн радиогийн холбоог үүсгэн байгуулсан. Монголын хүйн радиогийн холбоо нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж гишүүддээ зориулан сургалт семинар, хурал, хэлэлцүүлэг зохион байгуулж байлаа. Тухайлбал, 2012 онд “Монголын хүйн радио: одоо ба ирээдүй”, 2013 онд “Хүйн хэвлэл мэдээлэл, хүй олны хөгжил” сэдвээр хэлэлцүүлэг хийжээ. 2015 онд Монголын хүйн радиогийн холбоо нь Дэлхийн хүйн радиогийн ассоциац (World Association of Community Radio Broadcasters) –ын гишүүнээр элссэн юм. Үүний дараа Монголын хүйн радиогийн төлөөлөл Балба, Киргиз улсад очиж туршлага судалсан. Тодруулбал, Монголын төлөөлөгчид Бүгд Найрамдах Киргиз улсад туршлага судлахдаа ерөнхий боловс-ролын сургууль, их дээд сургуулийн ажиллуулдаг хүйн радиогийн үйл ажиллагаанд анхаарлаа хандуулжээ.

Хүйн радиогийн эрх зүйн байдал дэлхийн улс орнуудад тодорхойгүй байдаг гэдгийг өмнө нь дурдсан. Хууль, эрх зүйн орчин бүрдээгүй байгаа асуудал Монголын хүйн радиогийн үйл ажиллагаанд ч бэрхшээл учруулж байна. Монгол Улсад радио өргөн нэвтрүүлэг дамжуулах зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан Харилцаа холбооны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн ангилал, харилцаа холбооны салбарт

үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журмын дагуу олгодог. Радио давтамж ашиглах зөвшөөрөл авахад тусгай зөвшөөрөл шинээр авах, тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах гэсэн хоёр эрх зүйн харилцаа үйлчлэх бөгөөд тус тусдаа бичиг баримт бүрдүүлдэг. Тусгай зөвшөөрөл 5 жилийн хугацаанд хүчинтэй бөгөөд хүйн радиогийн хамт олон үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх зөвшөөрөл авахын тулд хугацаа нь дуусахаас 60 хоногийн өмнө Радио Телевизийн Сүлжээ УТҮГ-д хандах үүрэгтэй юм. Монгол Улсад хүйн радиогийн бүртгэл, үйл ажиллагаа явуулахтай холбоотой асуудлыг зохицуулсан хуулийн заалт байхгүй. Өөрөөр хэлбэл, Монголын хүйн радио нь арилжааны радиогийн адил статустай байна. Гэхдээ хүйн радио нь төрийн бус байгууллагын нэрээр бүртгүүлдэг. Хүйн радио нь төрийн бус байгууллагын бүртгэлтэй учир ашгийн төлөө бус, орлого олох боломж хязгаарлагдмал. Олсон орлогоороо эргэн хөрөнгө оруулалт хийхийг ашгийн бус загвар гэж хүлээн зөвшөөрдөггүй. Энэ нь манайд хүйн хэвлэл мэдээлэл өргөжин хөгжихөд саад бэрхшээл учруулдаг³.

Эцэст нь дүгнэхэд хүйн радио бол нутгийн оршин суугчдын мэдээллийн эрэлтэд тулгуурласан нэвтрүүлэг дамжуулах бололцоотой, иргэдийн оролцоог чухалчилдаг мэдээллийн хэрэгсэл юм. Манай улсад хүйн радиогийн эрх зүйн байдлыг хуулийн хүрээнд баталгаажуулах шаардлагатай байгаа бөгөөд хүйн хэвлэл мэдээллийн

хэрэгслийн тухай ойлголт хуульд огт байхгүй. Эрх зүйн үндсийг бүрдүүлж чадвал цаашдаа хүйн хэвлэл мэдээллийн хэрэгслийн зөвшөөрөл олгох асуудлыг хөнгөвчлөх, санхүүжилтийг ил тод болгох, татвараас чөлөөлөх гэх мэт асуудлыг шат дараатай шийдвэрлэх бололцоо нээгдэх юм.

Ишлэл

- ¹ Asociación Mundial de Radios Comunitarias. Principios para un marco regulatorio democrático sobre radio y TV comunitaria (исп.). — 2009. — p.4.
- ² Хүйн хэвлэл мэдээллийн тогтвортой байдлын суурь судалгаа. Глоб Интернэшнл Төв. УБ. 2019
- ³ Монголын хэвлэл мэдээллийн хөгжлийн үнэлгээ. УБ. 2016. х.60

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Андерсон Х. Нийтлэл нэвтрүүлгийг яаж бэлтгэх вэ? 2008. УБ.
2. Батжаргал Д. Радио сэтгүүл зүйн удиртгал. 2005. УБ.
3. Батжаргал Д, Мэндхүү Г. Радиогийн тухай А-Я хүртэл. 2015. УБ.
4. Дагиймаа Д. Радио сэтгүүл зүйн үндэс. 2009. УБ.
5. Норовсүрэн Л. “Радио сэтгүүл зүй” 2010. УБ.

Резюме

В статье рассматривается история возникновения коммюнити радиовещания в мире и дается краткая характеристика данного типа радиостанции в Монголии. Автор отмечает, что правовое положение коммюнити радио в Монголии нуждается в совершенствовании.